

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Аудитор Ч.Даваасүрэн	
	Утас: 99559722	Цахим хаяг: daavkach@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 115

танай _____ -ны № _____ -т

Г Хязгаарлалттай дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Улирлын үр дүнгийн урамшуулал дутуу олгосон Шатлал буруу тогтоосон, илүү цагийн нэмэгдэл дутуу бодож олгосон, ХАБ-ын хавсран ажилласаны нэмэгдэл олгосон, цалингийн нэмэгдлүүдийг илүү, дутуу тооцож олгосон, Цалин хөлсний орлогыг татвар, нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан, түлш шатахууныг тооцоо үүсгээгүй шууд зардал болгосон, анхан шатны баримтанд болон татварын цахим сайтад шивэгдээгүй 1 аж ахуйн нэгжтэй холбоотой гүйлгээ хийсэн, Татварын тодорхойлолтоорх цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй, хөрөнгийн тооллогын бүртгэл, нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй, шилэн дансны цахим системд мэдээлэх мэдээллийг хугацаанд бүрэн мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зэрэг 21.8 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татданы тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	83,728,723.00
33	АВЛАГА	0.00	47,298,700.00
335	Бусад авлага	0.00	47,298,700.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	47,298,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	36,430,023.00
351	Түүхий эд материал	0.00	18,056,770.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	17,927,000.00
35130	Эм боох материал	0.00	129,770.00
354	Хангамжийн материал	0.00	18,373,253.00
35420	Аж ахуйн материал	0.00	98,182.00
35460	Хүнсний материал	0.00	2,040,071.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	16,235,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	3,271,691,246.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	3,271,691,246.08
392	Биет хөрөнгө	0.00	3,270,811,246.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	3,136,236,695.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(17,423,537.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	58,248,725.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(2,006,178.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	98,462,565.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(4,415,947.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	1,830,990.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(122,065.92)
393	Биет бус хөрөнгө	0.00	880,000.00
39301	Програм хангамж	0.00	880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	3,355,419,969.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	310,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	310,000.00
413	Өглөг	0.00	310,000.00
4136	Бусад өглөг	0.00	310,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	310,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	3,355,109,969.08
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	3,355,109,969.08
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	3,355,109,969.08
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	3,355,109,969.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	3,355,419,969.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	3,622,567,657.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	3,202,707,057.83
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	3,202,707,057.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	3,202,707,057.83
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	0.00	3,201,783,875.83
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Барааматериал		923,182.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	419,860,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	367,490,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	367,490,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	52,370,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	52,370,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	267,457,688.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	267,457,688.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	260,180,991.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	154,684,003.00
210101	Үндсэн цалин	0.00	135,896,398.00
210104	Урамшуулал	0.00	18,787,605.00
2102	Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	19,319,805.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	17,486,405.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	453,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	381,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	90,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	907,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	52,005,349.43
210301	Гэрэл, цахилгаан	0.00	746,643.73
210302	Түлш, халаалт	0.00	50,430,141.70
210303	Цэвэр, бохир ус	0.00	828,564.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	5,640,910.00
210401	Бичиг хэрэг	0.00	551,400.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	388,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,701,510.00
2105	Нормативт зардал	0.00	4,303,194.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	344,000.00
210502	Хоол, хүнс	0.00	3,959,194.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	260,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	260,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	23,967,729.75
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	23,967,729.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	7,276,697.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	6,111,547.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	6,111,547.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	365,150.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	365,150.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	3,355,109,969.08

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулс	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	335,510,969.08	0.00	335,510,969.08
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	335,510,969.08	0.00	335,510,969.08

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	419,860,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	419,860,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	367,490,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.00	367,490,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	52,370,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	52,370,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	279,911,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	279,911,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	272,635,102.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	154,684,003.00
210101	Үндсэн цалин	0.00	135,896,398.00
210104	Урамшуулал	0.00	18,787,605.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	19,319,805.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	17,486,405.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	453,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	381,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	90,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	907,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	52,005,349.43
210301	Гэрэл, цахилгаан	0.00	746,643.73
210302	Түлш, халаалт	0.00	50,430,141.70
210303	Цэвэр, бохир ус	0.00	828,564.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	11,597,000.00
210401	Бичиг хэрэг	0.00	240,500.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	388,000.00
210404	Ном, хэвлэл	0.00	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	313,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	7,405,400.00
2105	Нормативт зардал	0.00	24,825,045.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	393,770.00
210502	Хоол, хүнс	0.00	6,011,275.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	18,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	3,016,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	3,016,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	7,187,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	7,187,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	7,276,697.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	6,111,547.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	6,111,547.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	365,150.57
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	365,150.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	139,948,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	139,948,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	139,948,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	139,948,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	139,948,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	(139,948,800.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	419,860,600.00	413,383,902.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	419,860,600.00	413,383,902.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,060,600.00	412,583,902.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	158,504,600.00	154,684,003.00
210101	Үндсэн цалин	139,704,600.00	135,896,398.00
210104	Урамшуулал	18,800,000.00	18,787,605.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,313,100.00	19,319,805.00
210201	Тэтгэврийн даатгал	19,497,600.00	17,486,405.00
210202	Тэтгэмжийн даатгал	453,900.00	453,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	363,100.00	381,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	90,800.00	90,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	907,700.00	907,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,370,500.00	52,005,349.43
210301	Гэрэл, цахилгаан	700,000.00	746,643.73
210302	Түлш, халаалт	50,670,500.00	50,430,141.70
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	828,564.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,801,000.00	11,597,000.00
210401	Бичиг хэрэг	250,000.00	240,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	425,000.00	388,000.00
210404	Ном, хэвлэл	250,000.00	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,000.00	313,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,426,000.00	7,405,400.00
2105	Нормативт зардал	24,850,400.00	24,825,045.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	395,000.00	393,770.00
210502	Хоол, хүнс	6,016,000.00	6,011,275.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,439,400.00	18,420,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	140,000,000.00	139,948,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	70,000,000.00	69,999,800.00
210602	Тавилга	70,000,000.00	69,949,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,021,000.00	3,016,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,021,000.00	3,016,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,200,000.00	7,187,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,200,000.00	7,187,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	419,860,600.00	413,383,902.43
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	367,490,100.00	361,378,553.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,490,100.00	361,378,553.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,370,500.00	52,005,349.43
122005	Орон нутгийн төсвөөс	52,370,500.00	52,005,349.43

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудиторын туслах Ч.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдарын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлийг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дүн 420.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.7 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн шатны материаллаг байдлыг тайлант оны нийт орлого 3,622.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцож шинэчлэн тогтоосон материаллаг байдал 72.4 сая төгрөг, шинэчлэн тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувьбуюу 57.9 сая төгрөг боллоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3,355.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 47.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлага нь АЙ БИ ӨҮ ХХК-аас авах багаж тоног төхөөрөмжийн үнэ байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36.3 сая төгрөг болж нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 42.0 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 6.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 36.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,295.6 сая төгрөг болж нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 93.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүй 3,201.7 сая төгрөгийн хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,355.0 сая төгрөг болж нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 3,355.0 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 419.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж 419.9 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 419.9 сая төгрөгийн төсөв баталснаас 367.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 52.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 367.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 52.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 413.4 сая төгрөгийг зарцуулж 6.1 сая төгрөгийг улсын төсөвт, 0.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 413.4 сая төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 3.8 сая төгрөгөөр, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 2.0 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.2 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.4 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 641.5 сая төгрөгийн 82 мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод мэдээлэхээс хугацаандаа 329.2 сая төгрөгийн 22 мэдээлэл мэдээлсэн, 311.7 сая төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй, 50 мэдээллийг хугацаа хоцроосон.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинээр байгуулагдсан байгууллага учраас өмнөх онд санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал, анхаарал татахуйц асуудал

Дараа жилийн аудитаар

- Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар, үнэнд дүн шинжилгээ хийх
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.9 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 19.8 сая төгрөгийн зөрчил, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчил, , шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Дэлхийн ОУБ-аас авсан хөрөнгий аудитын явцад залруулсан .

4.2 Төлбөрийн акт

- Улирлын үр дүнгийн урамшуулал 0.1 сая төгрөг дутуу олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно", 4.7-т "Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- Шатлал буруу тогтоосон, илүү цагийн нэмэгдэл дутуу бодож олгосон, ХАБ-ын хавсран ажилласаны нэмэгдэл олгосон, цалингийн нэмэгдлүүдийг илүү, дутуу тооцож 0.9 сая төгрөгийг илүү, 0.8 сая төгрөгийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- ✓ Цалин хөлсний орлогыг 0.1 сая төгрөгөөр татварын тайланд зөрүүтэй тайлагнасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйл, 7.1.1-т “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого “заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Цалингийн орлогыг нийгмийн даатгалын тайланд 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Түлш шатахууны 3.0 сая төгрөгийг тооцоо үүсгээгүй шууд зардал болгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө” заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах, УСНББОУС1 “Үнэн зөв ба толилуулга, нийцсэн байдал” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Анхан шатны баримтанд болон Татварын цахим сайтад шивэгдээгүй 1 аж ахуйн нэгжтэй холбоотой 1.1 сая төгрөгийн гүйлгээ байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно., Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг 6.5.Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- ✓ Татварын тодорхойлолтоорх цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын 1.3 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Шилэн дансны цахим системд 311.7 сая төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй, 50 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр " заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Хөрөнгийн тооллогын бүртгэл, нягтлан бодох бүртгэл 14.0 сая төгрөгөөр зөрүүтэй, тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн, тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй .

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэг	8	22.5	1	0.9	2	1.8	5	19.8		